



**НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДЭД ДАРГЫН ЗӨВЛӨМЖ**

2014 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 14/02

Улаанбаатар хот

."Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, хяналтын систем"-ийн
бүртгэлийг сайжруулах тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Том төрөөс ухаалаг төр рүү" санаачлагыг дэмжсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн зөвлөмж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр албан даалгавар, 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/511 дугаар болон 2014 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/1107 дугаар албан бичгүүдээр ирүүлсэн үүрэг, Улсын ерөнхий гүйцэтгэгчийн 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 03/4962 дугаар албан бичгээр ирүүлсэн ажил сайжруулах болон 2013 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 2в/644 дүгээр, 2014 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 2в/565 дугаар албан бичгээр ирүүлсэн тус тус ирүүлсэн үүрэг, тус албаны даргын 2013 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 13/37 дугаар тушаалаар өгсөн үүргийг хэрэгжүүлэх, "Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, хяналтын систем"-д мэдээлэл оруулах, баяжилтыг тухай бүр гүйцэтгэх чиглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийн явцад Шийдвэр гүйцэтгэх газраас гэнэтийн шалгалт хийхэд тус алба хангалтгүй дүн үзүүлсэн, цахим бүртгэл хөтлөлт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг ахиулах, дотоод хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр нийт ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, холбогдох албан хаагч нарт дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1.Ахлах шийдвэр гүйцэтгэгчдэд

1."Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, хяналтын систем"-д ахлах шийдвэр гүйцэтгэгч нар хариуцсан шийдвэр гүйцэтгэгчийн хийж буй бүртгэлийн баяжилтийг давхардуулалгүй, алдаагүй оруулсан бодит байдлыг хянаж, шийдвэр гүйцэтгэгч нэг бүрийн бүртгэлээр хяналтыг тавих,

2.Тухайн өдрийн ажлын мэдээг цахим бүртгэлийн системд баяжилт хийсэн байдлаар гарган нэгтгэх,

3."Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, хяналтын систем"-д оруулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баяжилт болон өдрийн мэдээг зөрүүлэхгүй, зөв гаргах, алдаатай гаргасан тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчид хариуцлага тооцуулах,

4.Дээрх системд мэдээлэл болон бүртгэл алдаатай шивэгдсэн тохиолдолд түүнийг 72 цагийн дотор засварлаагүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой дурдан, засвар оруулах саналыг албан бичгээр Шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэх,

5.Цахим бүртгэлд эрх олгогдоогүй зөвшөөрөлгүй хүнийг нэврүүлэхгүй байх, сүлжээний аюулгүй байдалд анхаарах,

6. "Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, хяналтын систем"-ээс гаргасан мэдээний файлыг өөрийн компьютерт сан/файл/ болгон хадгалах, хариуцсан хэсгийн шийдвэр гүйцэтгэгч бүрийн санг өдөр тутам хянах,

2.Нийт шийдвэр гүйцэтгэгчдэд

1.Шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцыг 2013 оны А/224 дүгээр тушаалаар батлагдсан "Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын системийн аюулгүй ажиллагааны журам"-д заасан хугацаанд оруулж, "Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, хяналтын систем"-д бүртгэн, өдөр бүр баяжилт хийх,

2.Өдрийн мэдээг системд баяжилт хийсэн байдлаар гаргах, мэдээг зөрүүлэхгүй, зөв гаргах, бодитой байх,

3.Системд холбогдох нууц үгийг задруулахгүй байх, сүлжээний аюулгүй байдалд анхаарал хандуулах,


3.Программ хангамж, мэдээлэл технологи хариуцсан ажилтан, бүртгэл хариуцсан ажилтан нарт

1.Программ хангамж, мэдээлэл технологи хариуцсан ажилтан нь "Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл, хяналтын систем"-д хийгдсэн баяжилтийг долоо хоног бүрээр шийдвэр гүйцэтгэгч, дүүрэг бүрээр гарган, бүртгэл хариуцсан ажилтанд хүргүүлэх,

2.Бүртгэл хариуцсан ажилтан дээрх бүртгэлийн системд хийгдсэн баяжилтыг албаны долоо хоногийн шуурхай мэдээтэй тулгах, зөрүүтэй, алдаатай мэдээ гаргасан бол энэ талаарх мэдээллийг даваа гараг бүрийн өглөөний шуурхай хуралдаанд танилцуулах, эрх бүхий албан тушаалтанд танилцуулгыг хүргүүлэх,

Уг зөвлөмжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллахыг та бүхнээс хүсье.

ДЭД ДАРГА, ХОШУУЧ



Ж.НАНДИНТУУЛ